



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтний хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ТУШААХ нь.

1. Мэс заслын камерын системийг ажиллуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Мэс заслын хяналтын камерын системийг мэс заслын тусламж, үйлчилгээнд мөрдүүлж хэвшүүлэхийг тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, амаржих газар, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, мэс заслын тасаг нэгжтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, амаржих газар, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, мэс заслын тасаг нэгжтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавихыг Мэдээлэл, хяналт- шинжилгээ, дотоод аудитын газар (дарга С.Төгсдэлгэр) -т даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 сарын
13 өдрийн 171 тушаалын хавсралт



МЭС ЗАСЛЫН ХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМИЙГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэс заслын тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, тусламж, үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу гүйцэтгэж байгаа байдалд хяналт тавих, мэс заслын багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх, багийн хариуцлагыг өндөржүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.2 Хяналтын камерын бичлэгийн ашиглалт нь Монгол Улсын Хувь хүний нууцын тухай хууль, Монгол Улсын Архивын тухай хуулийн 3 дугаар бүлгийн заалтаар зохицуулагдана.
- 1.3 Тухайн байгууллагын мэдээллийн технологийн хэлтэс(алба) буюу мэргэжилтэн нь хяналтын камерын системийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 1.4 Хяналтын камерын бичлэг хийх тухай үйлчлүүлэгчид танилцуулж, зөвшөөрөл авч бичлэг хийнэ.
- 1.5 Судалгаанд ашиглах тохиолдолд ёс зүйн хороонд танилцуулж, зөвшөөрөл авна.

Хоёр. Мэс заслын хяналтын камерын системийг ажиллуулах горим

- 2.1 Хяналтын камерын систем нь камер (гадна, дотно), хяналтын дэлгэц, бичлэг хадгалагч төхөөрөмж, тэжээлийн болон дүрс дамжуулах кабелиас бүрдэнэ.
- 2.2 Хяналтын болон сургалтын камерын тоо, байршлыг тухайн байгууллагын дарга, захирал тогтооно.
- 2.3 Хяналтын камерын систем нь бичигч төхөөрөмжийн хамт Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын өрөөнд байрлана.
- 2.4 Хяналтын камерын системийн бичлэг хадгалагч төхөөрөмж нь сүлжээний тусгай зориулалтын тоноглол бүхий өрөөнд байршина.

2.5 Хяналтын камерын систем нь мэс засал хийгдэх бүрт бичлэг хийх, хадгалахаар тохиргоо хийгдсэн байна.

2.6 Тухайн мэс заслын үед хийгдсэн бичлэгийг DVD дээр хуулж, архивт хадгална.

2.7 Хяналтын камерын бичлэг үзэхдээ байгууллагын дарга, захиралд заавал мэдэгдэж зөвшөөрөл авна.

2.8 Хэн ямар зорилгоор бичлэг үзсэн тухай тэмдэглэлийг тухайн байгууллагын сүлжээний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн хөтөлнө.

2.9 Хяналтын камерын бичлэгийг сургалт, судалгаанд ашиглана.

